БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## САЙХАН СУМЫН ЦЭЦЭРЛЭГ 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**Аудитын код: БУА-2023/105/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Булган аймаг<br>2023 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ<br>Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Баталгаат тооцоолол аудит ХХК<br>Захирал: М.Буянбулган<br>Утас: 77153069 Цахим хаяг:<br>buyanbulgan@batalgaattaudit.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой н эмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

эмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. «cityname»

**АГУУЛГА**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 2

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 4

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 10

**3.1 Байгууллага түүний үйл ажиллагаа** ..... 10

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин** ..... 10

**3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал** ..... 11

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд** ..... 11

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв** ..... 11

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 12

**4.1 Ерөнхий зүйл** ..... 12

**4.2 Материаллаг байдал** ..... 12

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 13

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 13

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 13

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 13

**4.5.1 Завсрын аудитын талаар** ..... 13

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 13

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 14

**5.1 Төлбөрийн акт** ..... 14

**5.2 Албан шаардлага** ..... 14

**5.3 Зөвлөмж** ..... 14

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


**БУЛГАН АЙМГИЙН**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn


2023.02.24 № 119

танай ________ ны № ________ т

САЙХАН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Э.БААСАНХҮҮ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхан сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэрлэг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын батлсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

2022 онд Боловсролын салбарт төсвийн шинэчлэл хийгдсэн ба улсын төсвөөс 280,676.9 мянган, орон нутгийн төсвөөс 38,799.5 мянган нийт 319,476.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оноос 66,565.0 мянган төгрөгөөр өссөн байна.

### Аудитын гол асуудал

Цэцэрлэг нь 2022 онд аймгийн Боловсролын газар болон сумын Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 97.5 хувийн биелэлттэйгээр тайлагнасныг сумын Засаг дарга хүлээн зөвшөөрч баталгаажуулсан байна.

006020129

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 36,824,606.68 | 72,134,973.41 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0,00 | 33,409,992.55 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 0,00 | 33,409,992.55 |
| **3121** | **Төгрөг** | 0,00 | 33,409,992.55 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0,00 | 33,409,992.55 |
| **32** | **БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 0,00 | 0,00 |
| **33** | **АВЛАГА** | 4,340,000.00 | 0,00 |
| **335** | **Бусад авлага** | 4,340,000.00 | 0,00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 4,340,000.00 | 0,00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 32,484,606.68 | 38,724,980.86 |
| **354** | **Хангамжийн материал** | 32,484,606.68 | 38,724,980.86 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 155,250.00 | 123,750.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 29,457,185.03 | 35,783,005.11 |
| 3546 | Хүнсний материал | 2,872,171.65 | 2,818,225.75 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 0,00 | 0,00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 470,783,104.28 | 435,423,924.90 |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 0,00 | 0,00 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 470,783,104.28 | 435,423,924.90 |
| **392** | **Биет хөрөнгө** | **465,181,484.28** | **430,159,804.90** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 451,431,240.20 | 449,259,240.20 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (28,921,765.09) | (48,141,041.17) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 33,322,510.00 | 23,918,357.98 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (14,397,050.21) | (12,787,444.63) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 58,169,211.50 | 45,536,409.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (36,863,182.12) | (30,066,236.98) |
| 39217 | Ном | 2,440,520.00 | 2,440,520.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **5,601,620.00** | **5,264,120.00** |
| 39301 | Програм хангамж | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (337,500.00) | (675,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,589,120.00 | 4,589,120.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 507,607,710.96 | 507,558,898.31 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 0,00 | 0,00 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0,00 | 0,00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **507,607,710.96** | **507,558,898.31** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 507,607,710.96 | 507,558,898.31 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 445,384,831.62 | 445,384,831.62 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (54,378,912.07) | (48,204,976.70) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (54,378,912.07) | (48,156,164.05) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0,00 | (48,812.65) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 116,601,791.41 | 110,379,043.39 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **507,607,710.96** | **507,558,898.31** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН(I)** | **253,095,449.00** | **322,727,700.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 0,00 | 0,00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **888,863.00** | **3,251,300.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 888,863.00 | 3,251,300.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 560,000.00 | 0,00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 328,863.00 | 3,251,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **252,206,586.00** | **319,476,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **225,441,100.00** | **280,676,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 0,00 | 280,676,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 225,441,100.00 | 0,00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **200,000.00** | 0,00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200,000.00 | 0,00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **26,565,486.00** | **38,799,500.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,565,486.00 | 38,799,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **286,117,596.15** | **322,776,512.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **286,117,596.15** | **322,776,512.65** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 261,512,210.26 | 322,776,512.65 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **160,602,919.00** | **191,801,468.00** |
| 210101 | Үндсэн цалин | 123,977,238.00 | 146,021,858.00 |
| 210102 | Нэмэгдэл | 21,093,419.00 | 36,801,394.00 |
| 210104 | Урамшуулал | 15,532,262.00 | 8,978,216.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **20,906,180.11** | **23,976,679.48** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,974,656.30 | 16,326,637.26 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,488,073.00 | 1,920,780.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,187,098.30 | 1,529,904.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 288,606.51 | 374,595.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,967,746.00 | 3,824,761.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **25,365,486.00** | **26,419,146.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,170,808.00 | 1,957,274.00 |
| 210302 | Түлш, халаалт | 23,630,464.00 | 23,630,464.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 564,214.00 | 831,408.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,619,700.00** | **6,653,629.92** |
| 210401 | Бичиг хэрэг | 686,300.00 | 22,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,692,000.00 | 0,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 464,500.00 | 0,00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,841,600.00 | 62,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 935,300.00 | 0,00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0,00 | 6,568,179.92 |
| **2105** | **Нормативт зардал** | **7,479,585.00** | **28,662,727.90** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 116,450.00 | 0,00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,231,135.00 | 28,662,727.90 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 132,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,353,900.00** | **1,095,960.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,353,900.00 | 1,095,960.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **93,700.00** | 0,00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 93,700.00 | 0,00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **243,500.00** | **590,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 243,500.00 | 0,00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 590,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **39,847,240.15** | **43,565,329.38** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 621,800.00 | 6,562,564.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,669,940.00 | 1,643,586.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 37,555,500.15 | 35,359,179.38 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **24,605,385.89** | **11,571.97** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **500,000.00** | 0,00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 0,00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **24,105,385.89** | **11,571.97** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,105,385.89 | 11,571.97 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 0,00 | 0,00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(33,022,147.15)** | **(48,812.65)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 0,00 | 0,00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 18,449,894.88 | 0,00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 18,449,894.88 | 0,00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (18,449,894.88) | 0,00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(51,472,042.03)** | **(48,812.65)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **252,911,451.00** | **319,476,400.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 0,00 | 0,00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **704,865.00** | 0,00 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 704,865.00 | 0,00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 704,865.00 | 0,00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **252,206,586.00** | **319,476,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **225,441,100.00** | **280,676,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 0,00 | 280,676,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 225,441,100.00 | 0,00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **200,000.00** | 0,00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200,000.00 | 0,00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **26,565,486.00** | **38,799,500.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,565,486.00 | 38,799,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **251,601,551.00** | **286,066,407.45** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **251,601,551.00** | **286,066,407.45** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **226,996,165.11** | **286,054,835.48** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 160,602,919.00 | 191,801,468.00 |
| 210101 | Үндсэн цалин | 123,977,238.00 | 146,021,858.00 |
| 210102 | Нэмэгдэл | 21,093,419.00 | 36,801,394.00 |
| 210104 | Урамшуулал | 15,532,262.00 | 8,978,216.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **20,906,180.11** | **23,976,679.48** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,440,764.08 | 16,326,637.26 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,621,705.59 | 1,920,780.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,294,004.36 | 1,529,904.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 314,694.90 | 374,595.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,235,011.18 | 3,824,761.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **25,365,486.00** | **26,419,146.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,170,808.00 | 1,957,274.00 |
| 210302 | Түлш, халаалт | 23,630,464.00 | 23,630,464.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 564,214.00 | 831,408.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,137,100.00** | **62,750.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 499,800.00 | 0,00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,680,000.00 | 0,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 464,500.00 | 0,00 |
| 210404 | Ном, хэвлэл | 49,800.00 | 0,00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,699,500.00 | 62,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,743,500.00 | 0,00 |
| **2105** | **Нормативт зардал** | **10,234,580.00** | **28,608,782.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 45,000.00 | 0,00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,744,880.00 | 28,608,782.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 444,700.00 | 0,00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,200,000.00** | **1,199,960.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,200,000.00 | 1,199,960.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **93,700.00** | 0,00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 93,700.00 | 0,00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **428,000.00** | **590,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 428,000.00 | 0,00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 590,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,028,200.00** | **13,396,050.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 789,200.00 | 10,404,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,239,000.00 | 2,992,050.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **24,605,385.89** | **11,571.97** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **500,000.00** | 0,00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 0,00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **24,105,385.89** | **11,571.97** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,105,385.89 | 11,571.97 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 1,309,900.00 | 33,409,992.55 |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | 0,00 | 0,00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,309,900.00** | 0,00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,309,900.00** | 0,00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **1,309,900.00** | 0,00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 1,309,900.00 | 0,00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | (1,309,900.00) | 0,00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 0,00 | 0,00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0,00 | 33,409,992.55 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0,00 | 0,00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0,00 | 33,409,992.55 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/ төгрөгөөр /*

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| D01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| D02 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 445 384 831,62 | 116 601 791,41 | (54 378 912,07) | 507 607 710,96 |
| D03 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0,00 | 0,00 | 6 222 748,02 | 6 222 748,02 |
| D04 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0,00 | 0,00 | 6 222 748,02 | 6 222 748,02 |
| D05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0,00 | (6 222 748,02) | | (6 222 748,02) |
| D09 | Тайлант үеийн үр дүн | 0,00 | 0,00 | (48 812,65) | (48 812,65) |
| D010 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 445 384 831,62 | 110 379 043,39 | (48 204 976,70) | 507 558 898,31 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0,00 | 0,00 | 0,00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 319,476,400.00 | 286,066,407.45 | 89.54 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 319,476,400.00 | 286,066,407.45 | 89.54 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 319,476,400.00 | 286,054,835.48 | 89.54 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 217,589,200.00 | 191,801,468.00 | 88.15 |
| 210101 | Үндсэн цалин | 184,339,600.00 | 146,021,858.00 | 79.21 |
| 210102 | Нэмэгдэл | 30,132,600.00 | 36,801,394.00 | 122.13 |
| 210104 | Урамшуулал | 3,117,000.00 | 8,978,216.00 | 288.04 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27,180,800.00 | 23,976,679.48 | 88.21 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,482,900.00 | 16,326,637.26 | 88.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,174,500.00 | 1,920,780.81 | 88.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,739,600.00 | 1,529,904.66 | 87.95 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 434,900.00 | 374,595.13 | 86.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,348,900.00 | 3,824,761.62 | 87.95 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 26,430,500.00 | 26,419,146.00 | 99.96 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,600,000.00 | 1,957,274.00 | 122.33 |
| 210302 | Түлш, халаалт | 24,130,500.00 | 23,630,464.00 | 97.93 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 700,000.00 | 831,408.00 | 118.77 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 62,800.00 | 62,750.00 | 99.92 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 62,800.00 | 62,750.00 | 99.92 |
| 2105 | Нормативт зардал | 33,017,000.00 | 28,608,782.00 | 86.65 |
| 210502 | Хоол, хүнс | 33,017,000.00 | 28,608,782.00 | 86.65 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,200,000.00 | 1,199,960.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,200,000.00 | 1,199,960.00 | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 592,000.00 | 590,000.00 | 99.66 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 592,000.00 | 590,000.00 | 99.66 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,404,100.00 | 13,396,050.00 | 99.94 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,404,100.00 | 10,404,000.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.00 | 2,992,050.00 | 99.74 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0,00 | 11,571.97 | 0,00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0,00 | 11,571.97 | 0,00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 319,476,400.00 | 319,476,400.00 | 100.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 280,676,900.00 | 280,676,900.00 | 100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 280,676,900.00 | 280,676,900.00 | 100.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 38,799,500.00 | 38,799,500.00 | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 38,799,500.00 | 38,799,500.00 | 100.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0,00 | 0,00 | 0,00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0,00 | 33 409 992,55 | 0,00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага түүний үйл ажиллагаа

Цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд сургуулийн өмнөх боловсролын зорилгыг бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино гэж чиг, үүргийг хуулийн 5.1, 5.2, 5.3 заалтад тодорхойлжээ.

2022 онд аймгийн Боловсролын газар болон сумын Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 97.5 хувийн биелэлтэйгээр тайлагнасныг сумын Засаг дарга хүлээн зөвшөөрч баталгаажуулсан байна. .

Боловсролын салбарт төсвийн шинэчлэлийн хүрээнд улсын төсвөөс улсын төсвөөс 280,676.9 мянган, орон нутгийн төсвөөс 38,799.5 мянган нийт 319,476.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өнгөрсөн оноос 66,565.0 мянган төгрөгөөр өсчээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сайхан сумын цэцэрлэг нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”;
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Цэцэрлэг эрхлэгчийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх журмыг боловсруулан батлаж, мөрддөг. Журамд тодорхойлсоны дагуу Дотоод хяналтын зөвлөлийг жилийн ажлын төлөвлөгөөний дагуу ажлуулдаг байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байгаа боловч аудитад үндэслэл болгох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Санхүүгийн үйл ажиллагаандаа Си Ти Эс програм ашигладаг.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.
Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48.9 мянган төгрөгөөр буурчээ.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 33,409.9 | 33,409.9 |
| Авлага | 4,304.0 | 0.0 | -4,304.0 |
| Бараа материал | 32,484.6 | 38,724.9 | -6,240.3 |
| Үндсэн хөрөнгө | 470,783.1 | 435,423.9 | -35,359.2 |
| **Нийт хөрөнгө** | **507,607.7** | **507,558.8** | **-48.9** |
| Өр төлбөр | | 0 | 0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 507,607.7 | 507,558.8 | -48.9 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **507,607.7** | **507,558.8** | **-48.9** |

Хүснэгтээс дэх 2022 оныг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулж гарсан өөрчлөлтийг судлан үзэхэд салбарын бодлогын шинэчлэлтэй холбоотой мөнгөн хөрөнгө 33,409.9 мянган төгрөгөөр өсч, бичиг хэргийн материалын эхний үлдэгдэл 31,500.8 мянган төгрөгөөр хорогдсон барааны, барилга байгууламж, орон сууцнаас 2,172.0 мянган, машин тоног төхөөрөмжөөс 9,404.2 мянган, тавилга эд хогшлоос 12,632.8 мянган нийт 24,208.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж,, 35,359.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгууллагдсан зэрэг нь үндсэн хөрөнгийг 35,359.2 мянган төгрөгөөр буурахад нөлөөлсөн ба оны эхний авлагаа бүрэн барагдуулжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төслөө зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 472.1 сая төгрөгөөр тооцож, төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналыг 152.6 сая төгрөгөөр бууруулж, 319.5 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 280.7 сая, орон нутгийн төсвөөс 38.8 сая төгрөгөөр баталсан байна. Зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 89.5 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Сайхан сумын цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, дотоод хяналтыг аудитын менежер Г.Батбаяр гүйцэтгэж, захирал М.Буянбулган хянан удирдаж, аудитын ажлын үе шатны болон гол хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар хэрэгжүүлэв.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд байгууллагын орлогын эх үүсвэр нь улс, орон нутгийн төсвөөс бүрддэг тул 2022 оны батлагдсан төсвийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн батлагдсан төсвийн нийт зардлын суурь үзүүлэлтээс 1.5 хувиар буюу 4,210,1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан дэд дарга, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тогтмол зардлыг 11.3 мянган, нормативт зардлыг 4,408.2 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

### 4.4Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус хэлтэс 2022 онд шилэн дансны сайтад 147 мэдээлэл байршуулахаас 144-ийг цаг тухай бүрд нь мэдээлсэн ба 3 мэдээлэл хугацаа болоогүй байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аудитын байгууллагын сонгон шалгаруулалтын хугацаанаас хамаарч завсрын аудит хийх боломжгүйд хүргэсэн. Аудитын нээлтийг 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 10 цагаас цахимаар эхлүүлж, аудит хийх мэдэгдэл, аудитад ирүүлэх баримтын мэдээллийн жагсаалтыг цахимаар болон биечлэн хүргүүлж, байгууллагуудын эхний хагас жилийн санхүүгийн тайланд судалгаа хийж, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт, байгууллагын талаарх мэдээлэлтэй танилцан аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэв.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус цэцэрлэг өмнөх онд түүвэрт хамрагдсан ба акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилт, завсрын аудитыг гүйцэхэд анхаарна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар батламж мэдэгдлийн хүрээнд эрх зүйн акт зөрчигдсөн[1] 1 алдаанд дахин давтан гаргахгүй байхад зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

***<u>Өгсөн зөвлөмж:</u>***

Хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй

***<u>Илрүүлэлт</u>:*** Жилийн эцсийн тооллогыг батлагдсан анхан шатны маягтын дагуу тооцоог бодож, баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д: Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал, хавсралтын Гурав. Бараа материалын үнэт зүйлийн маягтыг нөхөх зааврын 7 буюу Тооцоо бодсон баримт гэсэн заалтууд зөрчигдөхөд хүрнэ.

***<u>Өгсөн зөвлөмж</u>*:** Эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эрх зүйн актыг мөрдөөгүй | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 | 1 | 0.0 |
| Дүн | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 | 1 | 0.0 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эрх зүйн актыг мөрдөөгүй | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | | | |
| Дүн | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл